

ДЭВШИЛ МАНДАЛ ХК

Дундговь аймаг,
Сайнцагаан сум

Утас: 99300500

99095960

devshilmandal@outlook.com

2026-03-16

Дугаар 01/02

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйлүүдийн холбогдох заалтууд, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол зэргийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 09.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бага тойруу 26/1 барилгын 306 тоотод хуралдуулахаар тогтсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн тухай
 - 2.2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн тухай
 - 2.3. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай
 - 2.4. Компанийн санхүү болон үйл ажиллагаанд тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх талаар
 - 2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн сонгох
 - 2.6. Компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг хэлэлцэх
 - 2.7. Бусад
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй гишүүдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 08-ний өдрөөр тогтсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хурлын материалуудын хамт Монголын Хөрөнгийн бирж ХК, Санхүүгийн зохицуулах хороо зэрэгт цахимаар болон цаасан хэлбэрээр 2026 оны 3 дугаар сарын 20-ны дотор хүргүүлсүгэй
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2026 оны 03 дугаар сарын 20-н болон 04 дүгээр сарын 06-ны өдрүүдэд тутмын сонин хэвлэлээр болон цахимаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдахаас өмнө саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдэд танилцуулах материалын жагсаалтыг баталж, ажлын цагаар хурал хуралдах байранд танилцуулах ажлыг зохион байгуулсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах комиссын даргаар Д.Санжмятавыг, комиссын гишүүдээр С. Амармандахыг, М. Амарбаяр нарыг, тооллогын комиссын даргаар Г.Даваажамцыг, гишүүдээр Н.Сүхбаатар, Ц.Баянмөнх нарыг тус тус томилсугай.

Хурлын бэлтгэл ажлыг холбогдох хууль журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах тус комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.САНЖМЯТАВ